

Сайны төлөө бүх юмс хамтдаа ажилладаг

Далын Ахлагч Жеймс В.Мартино

Би хүүхэд байхдаа жил бүр хавар болохыг тэсч ядан хүлээдэг байлаа. Цаг агаар дулааран, зүлэг ногоорохоор бэйсбол тоглоход би бэлэн болдог байв. Би ихэнх хөвгүүдийн адил бейсболын шилдэг тоглогч болохыг хүсдэг байлаа. Надтай адил хүсэл мөрөөдөлтэй нэгэн хөвгүүний түүхийг би та бүхэнтэй хуваалцъя. Тэр ирээдүйн шилдэг бейсболын тоглогч болох хүслээр жигүүрлэн гадаа гарч, дасгал хийхээр болов. Тэрээр бейсболын бөмбөгийг дээш шидээд, өөрийнхөө бүхий л чадлаар хол цохих санаатай цохиураараа цохисон ч бөмбөг цохиурт ч хүрэлгүй газар уналаа. Тэрээр шилдэг тоглогч болох боломжоо алдахгүйн тулд ахин нэг оролдов. Бөмбөгөө агаарт шидэх тэрхэн агшинд хүчтэй цохих бодол төрж, түүний шийдэмгий байдал улам нэмэгдэнэ. Гэвч харамсалтай нь дахиад л оносонгүй. Бөмбөг газар унасан байв. Гэвч гурван цохилт хийгээд амжилтгүй болбол тэмцээнээс хасагддаг дүрмийг бейсболын тоглогч бүр мэднэ. Тэрээр анхаарлаа улам сайн төвлөрүүлэн, нэг гартаа бейсболын бөмбөг, нөгөө гартаа цохиур барьж бөмбөгөө дээш шидээд, хамаг тэнхээгээрээ далайн хүчтэй цохилоо. Тэр өмнө нь хэзээ ч ийм их хүч гаргаж байсангүй. Бөмбөг дахин газарт унахад, нүдэнд нь нулимс цийлэгнэв. Тэгтэл гэнэт нүүрэнд нь инээмсэглэл тодрон, “Би ямар мундаг бөмбөг шидэгч вэ!” гэж тэр хэллээ.

Энэхүү энгийн жишээ шиг сорилт бэрхшээл бидэнд тулгардаг ч эдгээрт хэрхэн хандах нь бидний амжилт болоод аз жаргалыг тодорхойлох болно. Хаана байгаагаас үл хамааран бид бүгдээрээ л зовлон бэрхшээлтэй тулгардаг. Судрууд бидэнд “бүх зүйлд сөрөг тал байх нь зайлшгүй”<sup>1</sup> хэмээн заасан байдаг. Хүн бүхэн хүндрэл бэрхшээлтэй цаг үеийг туулах болно. Тиймээс асуудлын гол учир нь хэзээ гэдэгт бус харин бид хэрхэн туулах вэ гэдэгт байдаг.

Христийн шашинтнуудын аль ч эрин үед байгаагүй хамгийн аймшигт зэрлэг хавчин гадуурхалтай Ромын Гэгээнтнүүд тулгарахаас хэдхэн жилийн өмнө Төлөөлөгч Паул сонирхолтой нэгэн сургамжийг заасан юм. Паул “Бурханыг хайрладаг хүмүүст сайны төлөө бүх юмс хамтдаа ажилладаг” гэдгийг гэгээнтнүүдэд сануулсан.<sup>2</sup> Тэнгэрлэг Эцэг маань биднийг төгс төгөлдөр хайраар хайрладаг. Тиймээс бидэнд Христтэй илүү адил болоход маань шаардлагатай зан чанаруудыг хөгжүүлэхэд туслах туршлагаудыг биеэрээ мэдрэх боломжийг олгодог. Бидэнд сорилтууд олон янзын хэлбэрээр ирж болно. Гэхдээ тэдгээрийг даван туулснаар бид Аврагчтайгаа илүү адил болж туршлагаасаа суралцах сайн

зүйлсийг олж мэддэг. Энэ сургаалыг ойлгосноор бид Эцэгийн хайрын талаар илүү агуу нотолгоог олж авдаг. Бидэнд эдгээр асуудлууд яагаад тулгарч байгааг бид энэ амьдралдаа мэдэж чадахгүй байж болох ч тухайн туршлагаас өсөж хөгжиж чадна гэдэгтэй итгэлтэй байж болно.

Эдүгээ, саад бэрхшээл болж өнгөрсөн хойно тухайн туршлагаас бид юу сурснаа эргэж харахад илүү хялбар байдаг ч, сорилтууд нь аливаа зүйлсийг мөнхийн байдлаар харах чадварыг өсгөхөд чиглүүлдгийг би ухаарсан юм. Заримд нь бидний саад бэрхшээл тийм ч хэцүү санагдахгүй байж болох ч саад бэрхшээл, туршлагыг туулж байгаа хүн бүрийн хувьд бодит бөгөөд биднийг Бурханы өмнө өөрсдийгөө даруусган, Түүнээс суралцахыг шаарддаг билээ.

Христийн амилалтын баярын энэхүү ням гарагт бид Аврагчийнхаа амьдралыг санан дурсдаг. Бид Түүний үйлс үйлдэл бүрийн үлгэр дууриалыг нь дагахыг хүсдэг билээ. Саад бэрхшээлийг даван туулахад маань туслах Аврагчийн энэ дэлхий дээрх сүүлчийн хэдэн цагийн амьдралаас суралцаж болох таван зүйлийн талаар би ярья.

Нэгдүгээрт: Тэр Өөрийн хүслийг бус харин Эцэгийнхээ хүслийг биелүүлсэн юм. Тэрээр зовлон бэрхшээлийг туулахдаа ч Өөрийнхөө ариун тохинуулалд тууштай хэвээр үлдсэн юм. Гетсеманий Цэцэрлэгт Тэрээр нүүрээрээ газар унан, “Эцэг минь, хэрэв та хүсч байгаа бол энэ аягыг Надаас зайлуулаач. Гэвч миний хүсэл бус, харин Таны хүсэл биелэгдэг” гэж гуйсан.<sup>3</sup> Заримдаа бид ирээдүйд тохиолдож болзошгүй зовлон бэрхшээлд бэлтгэгдэж, өсөн хөгжихийн тулд өвчин шаналлыг туулдаг. Эхчүүд ээ, би та нараас дараах асуултыг асууя, “Хүүхдүүд тань ямар ч буруу зүйл хийгээгүй байхад нь тэднийг өвтгөж, уйлуулах ямарваа нэгэн зүйлийг та хийх үү?” Мэдээж хэрэг та хийнэ! Эх хүн бүр л хүүхдийнхээ вакциныг (дархлаажуулалтыг) хийлгэхээр эмчид авч очдог бөгөөд бараг хүүхэд бүр л эмчийн өрөөнөөс уйлсаар гардаг. Та яагаад үүнийг хийдэг юм бэ? Учир нь одоогийн бяцхан өвдөлт тэднийг ирээдүйн болзошгүй өвчин шаналлаас хамгаалах болно гэдгийг мэдэж байгаа учраас... Тэнгэрлэг Эцэг маань эхлэлээс төгсгөл хүртэл бүгдийг мэддэг. Бид Аврагчийн үлгэр дууриалыг дагаж, Түүнд найдах хэрэгтэй.

Хоёрдугаарт: зовлон бэрхшээл тулгарахад бид гомдоллож, бувтналдахгүй байж сурах ёстой. Нифай агуу үзэгдэлд харсан Аврагчийн цагаатгагч золиослолын талаар бидэнд хэлэхдээ; “Иймийн тул тэд түүнийг ташуурдахад, мөн тэрээр үүнийг тэвчинэ; мөн тэд түүнийг цохиход, мөн тэрээр үүнийг тэвчинэ. Тийм ээ, тэд түүнийг нулимаж бөлгөө, мөн хүмүүний үрсийн зүг хандах өөрийн өгөөмөр хайр мөн өөрийн хүлцэнгүй тэсвэрлэлийн учир тэрээр үүнийг тэвчих болно”<sup>4</sup> гэсэн. Бид үргэлж асуудлыг засч залруулан, бэрхшээлийг даван туулахыг зорих

ёстой ч “Яагаад би гэж?” эсвэл “Би юу хийсэн гэж надад ийм юм тохиолдож байгаа юм бэ?” гэж асуухын оронд “Би юу хийх хэрэгтэй вэ? Үүнээс би юу сурч болох вэ? Би юугаа өөрчлөх вэ?” хэмээн асууж байх ёстой болов уу.

Хэдэн жилийн өмнө эхнэр бид хоёрыг Венесуэлд үйлчилж байхад бага хүү маань дасаж сурсан ахлах сургуулиа орхин, бидэн дээр ирсэн юм. Хэдийгээр тэр гомдоллоогүй ч, бүх зүйл шинэ байсан тул амаргүй байгаа нь илэрхий байлаа. Гэвч тэрхүү сорилт нь түүний амьдралд асар том адислал болон хувирсан нь төсөөлж ч байгаагүй зүйл болсон юм. Тэр өөрийн зан төлөвийг өөрчилж, амжилтанд хүрэх шийдвэрийг хөгжүүлснээр энэ адислалыг хүртсэн билээ.

Гуравдугаарт: саад бэрхшээлтэй тулгарах үед бид илүү агуу тусламжийг Бурханаас эрэлхийлэх ёстой. Бид бүгдийн Аврагч хүртэл Гетсеманий Цэцэрлэгт байхдаа “маш шаргуу”<sup>5</sup> залбирах хэрэгтэйг олж мэдсэн билээ. Хэрэв бид үүнийг хийх юм бол агуу итгэлтэй болж чадна. Тэнгэрлэг Эцэгээс маань ирэх хариултауд нь ихэнхдээ зовлон бэрхшээлийг биднээс зайлуулдаггүй, харин тэдгээр бэрхшээлүүдийг даван туулахад хүчирхэгжүүлж тусалдаг гэдгийг бид санах ёстой. Их Эзэн Алмагийн дагалдагчдад үйлдсэний адилаар, “та нарын мөрөн дээр тавигдах ачаануудыг, бүр та нарын нуруун дээрээ байгаа ч мэдрэхгүй”<sup>6</sup> болгож чадна. Зовлон зүдгүүр тулгарахад хорсолтой эсвэл гуйвамтгай байлгүй харин бүгд Аврагчийн жишээг дагацгаан илүү хичээнгүй, илүү чин сэтгэлээсээ бөгөөд итгэлтэй байцгаая.

Дөрөвдүгээрт: зовлон зүдгүүртэй үедээ ч гэсэн бусдад санаа тавьж, тэдэнд үйлчилж сурцгаая. Христ бол үйлчлэлийн хамгийн агуу жишээ байсан. Түүний амьдрал бусдад туслан, үйлчилсэн жишээгээр дүүрэн байсан бөгөөд хамгийн агуу бэлэг нь Түүний бидний төлөө хийсэн зүйл юм. Тэрээр, “Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ”<sup>7</sup> хэмээн хэлсэн. Бид наманчлаад, дараа нь Түүний үйлчлэлийн жишээг дагах ёстой. Бид бусдад үйлчлэхдээ өөрсдийнхөө асуудлуудыг мартаж, бусдын өвдөлт эсвэл сэтгэлийн шаналлыг зөөллөхөөр ажиллахдаа хүчирхэгжиж байдаг.

Сүүлчийн ерөнхий чуулган дээр бидний хайрт Бошиглогч, Ерөнхийлөгч Томас С.Монсон “Бид бусдад үйлчлэхэд өөрсдийгөө зориулахгүй бол бидний амьдралын зорилго өчүүхэн юм гэдгийг Аврагч бидэнд захиж хэлсэн гэдэгт би итгэдэг. Зөвхөн өөрийнхөө төлөө амьдардаг хүмүүс эцэстээ хатаж хорчийдог, зүйрлэвээс амиа алддаг бол бусдад үйлчлэхэд өөрсдийгөө зориулдаг хүмүүс өсөж дэвжин амиа авардаг билээ”<sup>8</sup> гэж хэлсэн.

Тавдугаарт: бусдыг уучилж, өөрсдийнхөө нөхцөл байдлын бурууг тэдэнд тохохыг бүү эрэлхийл. Заримдаа бид, “Хэрэв тэд ийм юм хийгээгүй байсан бол би ийм хариу үйлдэл гаргахгүй байсан” гэж хэлэх дуртай байдаг. Эгэл хүмүүн нь өөрсдийнхөө үйлдлүүдэд хариуцлага хүлээхгүйн тулд бурууг бусдад тохох гээд байдаг зантай. Аврагч маань Өөрийг нь загалмайд хадаж буй хүмүүсийг хараад Тэнгэр дэх Эцэгтээ хандан “тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна”<sup>9</sup> хэмээн гуйсан. Бид илүү уучламтгай байж чадахгүй гэж үү?

Амьдралын зовлон бэрхшээлийг туулахдаа мөнхийн өсөлтөө хадгалж, гомдоллон үглэлгүй, бүр илүү залбиралтай болцгоож, бусдад үйлчилж, бие биеэ уучилцгаая. Бид үүнийг хийснээр “Бурханыг хайрладаг [бидний] сайны төлөө бүх юмс хамтдаа ажиллах [болно].”<sup>10</sup> Эцэг маань бидэнд хайртай бөгөөд Тэр бидэнд замыг маань зааж, засч залруулах Хүүгээ илгээснийг би баттай гэрчилж байна. Амьдралынхаа зовлон зүдгүүрийн үед ч бид “баясгалантай байж болох”<sup>11</sup>–ыг Тэр хүссэн болохоор Тэр зовсон, Тэр амиа өгсөн, мөн бид амьдарч болохын тул Тэр амилсан юм. Үүнийг би Есүс Христийн нэрээр хэллээ, амен.

## ЭШЛЭЛ

1. 2 Нифай 2:11.

2. Ром 8:28.

3. Лук 22:42.

4. 1 Нифай 19:9.

5. Лук 22:44.

6. Мозая 24:14.

7. Сургаал ба Гэрээ 19:16.

8. Томас С.Монсон “Өнөөдөр би хэн нэгний төлөө юу хийв?” *Лиахона*, 2009 оны арваннэгдүгээр сар, 85.

9. Лук 23:34.

10. Ром 8:28.

11. 2 Нифай 2:25.